



АСРАН ХАМГААЛАЛЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Хүндэт эцэг эхүүдэд,

Гэр бүл салах, тусдаа амьдрах тохиолдолд эцэг эх, асран хамгаалагчийн аль нэг нь хүүхдээ асран хамгаалах бол сургууль хүүхдийн талаарх тусгай хүсэлт, зааварчилгааг авдаг. Хууль эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгож, үл ойлголцол үүсэхээс сэргийлэхийн тулд дараахь мэдээллийг хүсэж байна. Ихэнх эцэг эх энэ талаархи зохих дүрэм, журмыг мэддэг боловч зарим эцэг, эх асран хамгаалах эрхийн талаарх мэдээлэл аваагүй байдаг болохыг бидний туршлага харуулж байна. Олон нийтийн тухай хуулийн 93-380, Гэр бүлийн боловсролын эрх ба нууцлалын тухай хууль (FERPA), Иллинойсын олон нийтийн тухай хуулийн 85-1389-г заасны дагуу:

“Гэр бүл салах, тусдаа амьдрах тохиолдолд FERPA хуулийн дагуу эцэг эхийн аль нэгийн эрхийг тусгайлан хассан хууль ёсны хүчин төгөлдөр баримт бичиг байхгүй бол сургуулийн Дүүрэг төрүүлсэн эцэг эх, албан ёсны болон албан бус асран хамгаалагч нарт аль алинд нь тэгш эрхтэй хандах ёстой. Энэхүү эрхийг хассан тусгайлсан хууль ёсны баримт бичиг нь хүүхдийнхээ боловсролын хувийн мэдээлэлд нэвтрэхийг хориглосон, эсвэл сургуулийн дүнгийн тайлан мэдээлэл авах эцэг, эхийн эрхийг хассан тухай шүүхийн БАТЛАМЖ эсвэл хууль эрх зүйн баримт бичиг байна. Мөн энэхүү баталгаажуулсан шүүхийн шийдвэрт эцэг эх хүүхэдтэйгээ сургууль дээр хэзээ, хаана холбоо барьж, уулзаж болох тухай нөхцлүүдийг тусгасан байх шаардлагатай”

Эцэг эх хүүхдийнхээ асран хамгаалалттай холбоотой тусгай мэдээллийг сургуульд өгдөг тул Дүүрэг түүнийг хууль ёсны дагуу хэрэгжүүлэх боломжгүй тул энэхүү зааварчилгааг өгөх шаардлага гардаг. Гараар бичсэн тэмдэглэл, утсаар ярих, бүртгэлийн хуудсан дээрх тайлбар зэрэг нь хуульд нийцсэн зүйл биш юм. Сургууль нь аливаа хязгаарлалтыг тэмдэглэсэн шүүхийн баталгаажуулсан шийдвэрийн хуулбарыг заавал авсан байх ёстой. Энэ нь сурагчийн хувийн хэрэгт хадгалагддаг. Хэрэв танд нэмэлт асуулт байвал 847-998-5005 утас руу болон сургуулийн оффис руу залгаарай. Шүүхийн захирамжын тухай мэдээлэл болон хуулийн арга хэмжээний талаарх асуултад таны өмгөөлөгч, шүүх байгууллага туслалцаа үзүүлнэ.

Хүндэтгэсэн,
Dane Delli, Ph.D.
Тэргүүн Удирдагч